

Хил хязгааргвй и-ажил вйлчилгээ төслийн 2-р шатанд хийгдэж байгаа ажлын танилцуулга /2001.12.12/

Энэхвв төслийн 1-р хэсэг буюу урьдчилсан судалгааны хэсгийг Наранцэцэг захиралтай Инфокон ХХК гвйцэтгэсэн билээ. Судалгааны вр дvнд Бодькомпьютер, Интерактив, Оргилтех, Инженерсофт, Инфокон, ЖЭМР, Датаком, БСБ компаниудыг өгөгдөхввн оруулах туршилтын ажлын хэсэг болгон зохион байгуулсан юм.

Төслийн 2-р шатанд эдгээр компанийн төлөөлөгчид уулзалт зохион байгуулж, МИДАС ТББ-ийн дэргэд дээр дурьдсан ажлын хэсэг хамтран ажиллахаар тохиролцон Нацагдоржийг бvлгийн ахлагчаар сонгосон болно. Инженерсофт ХХК бусад ажлын ачааллаасаа хамааран хамтран ажиллах бололцоогвйгээ мэдэгдэж энэхвв бvлгээс гараад байна.

Төслийн 2 шат нь өгөгдхввн оруулах ажил вйлчилгээг туршиж, цаашид энэхвв төрлийн ажлыг Монголд оруулж ирэх туршилтыг хийх явдал юм. Одоогоор АНУ-аас 1800 оны вед хэвлэгдэж байсан сонингуудыг зураг хэлбэрээр хвлээн авч тvvнийг текст хэлбэрт шилжvвлэх туршилт хийгдэж байна.

Бодь компьютер ХХК өөрийн серверээр АНУ-аас зургийн файлуудыг татан авч МИДАС ТББ-ын ажлын алба тухайн төслийн зургийн файлуудыг бvртгэн бvлгийн гишvвн, оролцогч байгууллагуудад тараах, буцааж хвлээн авах, шалгах, Бодь компьютер компаниар дамжуулан буцаан илгээх гэх мэтийн зохион байгуулалтын ажлыг тvр хугацаанд гвйцэтгэж байна. Мөн E-job@ict.mn мэйлинг лист vvcгэж оролцогсдын хооронд мэдээлэл солилцож байна.

Ажлын хэсэг өгөгдхввн оруулах ажлын туршилтыг амжилттай хэрэгжvвлж байна. Ялангуяа тухайн компаниудад ашигтай байх технологи бий болгох асуудал нилээдгвй анхаарал тавин ажиллааж ирлээ.

Эхний туршилтын ажил бvх компаниудад тараагдан хийгдсэн бөгөөд тvvнийг хийх явцдаа ямар технологи ашигласан, тэдгээрийн давуу ба сул талуудын талаар хамтран мэдээлэл солилцож ярилцан боломжит технологийг бий болгосон. Vvнд:

- Хоёр бичээч тус тусдаа шивснийг гурав дах хvн харьцуулж эх хувьтай тулган засварлах
- OCR ашиглан хоёр хvн оруулж шалгах

Интерактив ХХК-ийн захирал Ганболд эдгээр хувилбарт зориулсан вг вгэр харьцуулах программ боловсруулсан.

Эхний технологи нь харьцангуй өндөр өртөгтэй байсан ба хоёр дох хувилбарын хувьд компаниуд өөр өөр OCR-ийн программ ашиглан оруулсан нь 80-85 хувийнг зөв уншсан байна. Тиймээс 2 дох хувилбар нь өртгийн хувьд хямд байлаа.

Эдгээр технологийг тус төслийн зөвлөх Жереми-д илгээн санал бодолыг авч ажлын хэсэг дор дурьдсан дахин өөр хоёр хувилбар дэвшvвлсэн байна.

Эхний хувилбар нь: Эхний бичээч өгөгдхввнийг шууд оруулах ба хоёр дах нь шивэх явцад эхний бичээчийн шивсэн текстэй харьцуулалт давхар хийгдэн явах юм. Хоёр дох хувилбар нь хоёр бичээч тус тусдаа OCR ашиглан оруулж тэдгээрийн вр дvнг хооронд жишиж хянах.

Хоёр хувилбаруудын дараа tag тавих программын тусламжтайгаар tag-уудыг байрлуулна.

Эдгээр хувилбаруудад зориулан Ганболд дараах шинэ программуддыг зохиогоод байна. Үүнд:

- SW1 хоёр текст файлыг хооронд нь жиших
- SW2 tag тавих ба шалгах
- SW3 шивж байгаа текстийг өмнөх тексттэй харьцуулах

Хүрсэн үр дүн:

- Хамтран ажиллах ажлын хэсэг бүрдсэн
- Технологи бий болгон сонгож, туршиж эхэлсэн
- Технологиудад шаардлагатай программ хангамжууд боловсруулагдсан
- Эдгээр программ хангамжууд нь зөвхөн энэ ажил үйлчилгээнд төдийгүй бусад баримтыг харьцуулахад хэрэглэгдэж болох юм.

Тулгарч буй асуудлууд:

- Ажлын хэсэг Жеремитэй харьцахад заримдаа хэлний барьераас болоод төөрөлдөх асуудал байсан
- Tag оруулах зааварчилгаа авсан боловч ирж буй сонингуудын өгүүлэлүүдийн төрөл бүрээс болж tag-тай холбоотой асуудлууд мөн гарсаар байна..

Цаашид шийдэх асуудлууд:

- Бусад компаниудад зөвлөх чадавхи бүрдүүлэх үүднээс оролцогч компаниудын туршлагыг нэмэгдүүлэх
- Бусад сонирхогч талуудыг татан оролцуулах
- Тухайн ажлыг зохион байгуулах байнгын ажлын алба зохион байгуулах
- Бие даан гадаадаас ажил олох стратеги бий болгох